

**Говьсүмбэр аймаг дахь
Төрийн аудитын газар**



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2022/65/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Чойр хот 2022 он</p>	<p>Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас:70543156 Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Г.Наранбаяр Утас:70543179 Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Ц.Батсайхан Утас: 70543179 Цахим хаяг: Batsaikhants@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	15
3. Аудитын тайлан	16
3.1 Ерөнхий зүйл.....	16
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	16
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	16
3.4 Материаллаг байдал	17
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	17
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	19
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	21
3.8 Аудитын гол асуудал	21
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	21
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	21
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	22
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	22
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	22
4. Аудитын илрүүлэлт	23
4.1 Залруулсан алдаа.....	23
4.2 Төлбөрийн акт.....	23
4.3 Албан шаардлага	23
4.4 Зөвлөмж	24
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	25

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГСА	Говьсүмбэр аймаг
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨД	Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан
ХЧТАТ	Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж
ЭХМК	Эмнэлэг хөдөлмөр магадлах комисс



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: govisumber@audit.gov.mn

2022.02.25 № 19

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн "Нийгмийн даатгалын хэлтэс"-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн "Нийгмийн даатгалын хэлтэс"-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

4208020073

Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	9,634,384,833.90	11,663,281,471.09
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,529,463,062.71	4,176,630,185.17
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,529,463,062.71	4,176,630,185.17
31210	Төгрөг	2,529,463,062.71	4,176,630,185.17
31211	Төрийн сангийн харилцах	92,280,310.72	47,757,386.81
31213	Арилжааны банк дахь харилцах	2,437,182,751.99	4,128,872,798.36
33	АВЛАГА	7,092,903,038.19	7,478,529,302.92
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	5,925,740,759.40	6,072,599,936.65
33300	Татаас, санхүүжилтийн авлага	1,151,185,286.68	1,374,557,046.26
33500	Бусад авлага	15,976,992.11	31,372,320.01
33510	Байгууллагаас авах авлага	15,724,530.01	31,372,319.01
33520	Хувь хүмүүсээс авах авлага	252,462.10	1
35	БАРАА МАТЕРИАЛ	12,018,733.00	8,121,983.00
35400	Хангамжийн материал	12,018,733.00	8,121,983.00
35410	Бичиг хэргийн материал	394,000.00	503,900.00
35420	Аж ахуйн материал	6,936,753.00	6,701,863.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,153,400.00	473,000.00
35470	Бусад хангамжийн материал	3,534,580.00	443,220.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	802,344,630.47	783,161,752.02
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	802,344,630.47	783,161,752.02
39200	Биет хөрөнгө	778,275,630.47	759,092,752.02
39201	Барилга, байгууламж, орон сууц	812,475,675.68	812,475,675.68
39202	Хуримтлагдсан элэгдэл	-86,595,390.70	-102,158,539.66
39203	Авто-тээврийн хэрэгсэл	41,000,000.00	41,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-38,722,222.22	-41,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	58,771,849.38	41,642,494.38
39206	Хуримтлагдсан элэгдэл	-34,827,509.50	-13,162,479.21
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	59,136,270.00	57,530,270.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-32,963,042.17	-37,234,669.17
39300	Биет бус хөрөнгө	24,069,000.00	24,069,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	24,069,000.00	24,069,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	10,436,729,464.37	12,446,443,223.11
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	153,072,382.28	198,251,989.35
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	153,072,382.28	198,251,989.35
41300	Өглөг	134,705,652.67	170,894,281.46
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	252,462.10	0
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	134,453,190.57	170,894,281.46
41400	Урьдчилж орсон орлого	18,366,729.61	27,357,707.89

Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	18,366,729.61	27,357,707.89
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,283,657,082.09	12,248,191,233.76
51	Засгийн газрын хувь оролцоо	10,283,657,082.09	12,248,191,233.76
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	150,010,138.98	150,010,138.98
51200	Хуримтлагдсан үр дүн	10,026,167,805.06	11,990,701,956.73
51210	Өмнөх үеийн үр дүн	5,868,678,654.35	10,034,845,303.07
51220	Тайлант үеийн үр дүн	4,157,489,150.71	1,955,856,653.66
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	107,479,138.05	107,479,138.05
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	10,436,729,464.37	12,446,443,223.11

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	21,662,557,981.85	20,295,131,377.83
11	ТАТВАРЫН ОРЛОГО	14,772,047,573.47	16,267,074,892.66
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	14,772,047,573.47	16,267,074,892.66
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	10,069,540,568.21	11,273,156,572.75
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,047,839,125.40	1,109,391,592.43
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,121,243,205.69	1,177,472,034.65
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	210,126,531.06	225,582,103.69
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	2,323,298,143.11	2,481,472,589.14
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	50,399,073.80	31,873,298.17
120	Нийтлэг татварын бус орлого	50,399,073.80	31,873,298.17
120002	Хүүгийн орлого	43,028,295.42	14,985,966.86
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,495,779.38	4,119,331.31
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,026,768.28	3,808,834.61
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	469,011.10	310,496.70
120009	Бусад орлого	874,999.00	0

Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0	12,768,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,840,111,334.58	3,996,183,187.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	105,400,000.00	0
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	105,400,000.00	0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,912,000.00	285,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,912,000.00	285,000.00
1330	Төсвийн захирагчдаас	6,453,925,334.58	3,720,084,587.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,453,925,334.58	3,720,084,587.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	278,874,000.00	275,813,600.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	278,874,000.00	275,813,600.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	17,505,068,831.14	18,339,274,724.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	17,505,068,831.14	18,339,274,724.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	308,335,119.41	301,438,734.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	189,523,649.00	189,688,745.00
210101	Үндсэн цалин	145,551,711.00	126,152,962.10
210102	Нэмэгдэл	28,982,700.00	52,215,782.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,076,000.00	11,320,000.00
210104	Урамшуулал	2,913,238.00	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,296,910.00	25,139,152.00
210201	Тэтгэврийн даатгал	16,264,351.56	17,393,779.28
210202	Тэтгэмжийн даатгал	2,009,354.46	1,935,714.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,606,025.75	1,548,571.76
210204	Ажилгүйдлийн даатгал	400,899.01	387,142.94
210205	Эрүүл мэндийн даатгал	4,016,279.22	3,873,943.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,136,802.00	26,945,217.00
210301	Гэрэл, цахилгаан	3,351,247.00	2,732,954.00
210302	Түлш, халаалт	24,950,875.00	23,512,263.00

Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус	834,680.00	700,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,088,070.00	8,806,400.00
210401	Бичиг хэрэг	2,112,220.00	2,101,800.00
210402	Тээвэр, шатахуун	2,039,900.00	1,976,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,423,942.00	1,138,040.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,392,008.00	3,469,860.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	888,900.00	5,268,842.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	319,000.00	2,870,842.00
210604	Урсгал засвар	569,900.00	2,398,000.00
2107	Томилолт, зочны зардал	600,000.00	777,000.00
210702	Дотоод албан томилолт	600,000.00	777,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,493,567.20	9,258,899.89
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,150,108.00	4,247,772.89
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,080,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	798,250.00	797,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55,900.00	55,900.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,013,850.00	987,080.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,395,459.20	3,171,047.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,307,221.21	35,554,478.45
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	470,650.00	1,123,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	38,836,571.21	34,430,878.45
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,196,733,711.73	18,037,835,989.83
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,722,477,112.00	14,635,305,429.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	13,713,977,112.00	14,630,905,148.00

Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,500,000.00	4,400,281.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,474,256,599.73	3,402,530,560.83
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,474,256,599.73	3,402,530,560.83
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	4,157,489,150.71	1,955,856,653.66
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	4,157,489,150.71	1,955,856,653.66

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	150,010,138.98	107,479,138.05	5,922,484,475.23	6,179,973,752.26
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	-53,805,820.88	-53,805,820.88
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	150,010,138.98	107,479,138.05	5,868,678,654.35	6,126,167,931.38
9	Тайлант үеийн үр дүн	0	0	4,157,489,150.71	4,157,489,150.71
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	150,010,138.98	107,479,138.05	10,026,167,805.06	10,283,657,082.09
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	150,010,138.98	107,479,138.05	10,026,167,805.06	10,283,657,082.09
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	8,677,498.01	8,677,498.01
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	150,010,138.98	107,479,138.05	10,034,845,303.07	10,292,334,580.10
19	Тайлант үеийн үр дүн	0	0	1,955,856,653.66	1,955,856,653.66
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	150,010,138.98	107,479,138.05	11,990,701,956.73	12,248,191,233.76

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	18,152,717,240.45	19,940,510,477.37
11	ТАТВАРЫН ОРЛОГО	11,350,337,782.60	15,887,585,734.12
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	11,350,337,782.60	15,887,585,734.12
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	7,664,207,487.18	11,088,798,694.73
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	775,154,714.00	1,027,712,280.71
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	840,484,783.39	1,103,627,130.41
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	156,822,182.13	209,810,142.27
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	1,913,668,615.90	2,457,637,486.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	87,693,457.85	41,254,843.25
120	Нийтлэг татварын бус орлого	87,693,457.85	41,254,843.25
120002	Хүүгийн орлого	43,028,295.42	14,985,966.86
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	44,665,162.43	26,268,876.39
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	44,196,151.33	25,958,379.69
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	469,011.10	310,496.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,714,686,000.00	4,011,669,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0	18,671,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0	18,671,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,912,000.00	285,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,912,000.00	285,000.00
1330	Төсвийн захирагчдаас	6,433,900,000.00	3,716,900,000.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,433,900,000.00	3,716,900,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	278,874,000.00	275,813,600.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	278,874,000.00	275,813,600.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	17,459,666,754.72	18,293,343,354.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	17,459,666,754.72	18,293,343,354.91

Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	265,956,747.00	263,473,126.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	189,523,649.00	189,688,749.00
210101	Үндсэн цалин	145,551,711.00	126,152,966.10
210102	Нэмэгдэл	28,982,700.00	52,215,782.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,076,000.00	11,320,000.00
210104	Урамшуулал	2,913,238.00	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,006,181.00	25,139,152.00
210201	Тэтгэврийн даатгал	16,069,737.56	17,393,779.28
210202	Тэтгэмжийн даатгал	1,985,311.17	1,935,714.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,586,808.56	1,548,571.76
210204	Ажилгүйдлийн даатгал	396,101.99	387,142.94
210205	Эрүүл мэндийн даатгал	3,968,221.72	3,873,943.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,136,802.00	26,945,217.00
210301	Гэрэл, цахилгаан	3,351,247.00	2,732,954.00
210302	Түлш, халаалт	24,950,875.00	23,512,263.00
210303	Цэвэр, бохир ус	834,680.00	700,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,425,457.00	8,681,410.00
210401	Бичиг хэрэг	2,006,600.00	2,211,700.00
210402	Тээвэр, шатахуун	2,039,900.00	1,976,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,423,942.00	1,138,040.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,835,015.00	3,234,970.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,695,900.00	4,588,442.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,126,000.00	2,190,442.00
210604	Урсгал засвар	569,900.00	2,398,000.00
2107	Томилолт, зочны зардал	600,000.00	777,000.00
210702	Дотоод албан томилолт	600,000.00	777,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,098,108.00	6,529,556.89
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,150,108.00	4,247,772.89
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,080,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	798,250.00	797,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	55,900.00	55,900.00

Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,013,850.00	987,080.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0	441,704.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	470,650.00	1,123,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	470,650.00	1,123,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,193,710,007.72	18,029,870,228.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,719,453,407.99	14,627,964,567.19
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	13,704,605,886.68	14,585,503,371.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,500,000.00	4,400,281.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,347,521.31	38,060,915.19
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,474,256,599.73	3,401,905,660.83
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,474,256,599.73	3,401,905,660.83
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	693,050,485.73	1,647,167,122.46
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	693,050,485.73	1,647,167,122.46
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,836,412,576.98	2,529,463,062.71
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,529,463,062.71	4,176,630,185.17

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /				
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,170,690,300.00	14,852,650,074.89	318,040,225.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,170,690,300.00	14,852,650,074.89	318,040,225.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	272,299,600.00	262,746,422.89	9,553,177.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	193,381,600.00	189,688,749.00	3,692,851.00
210101	Үндсэн цалин	147,194,100.00	126,152,966.10	21,041,133.90
210102	Нэмэгдэл	30,182,700.00	52,215,782.90	-22,033,082.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,924,800.00	11,320,000.00	3,604,800.00

Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210104	Урамшуулал	1,080,000.00	0	1,080,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,139,500.00	25,139,152.00	348.00
210201	Тэтгэврийн даатгал	17,404,300.00	17,393,779.28	10,520.72
210202	Тэтгэмжийн даатгал	1,933,800.00	1,935,714.70	-1,914.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,547,100.00	1,548,571.76	-1,471.76
210204	Ажилгүйдлийн даатгал	386,800.00	387,142.94	-342.94
210205	Эрүүл мэндийн даатгал	3,867,500.00	3,873,943.32	-6,443.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,693,700.00	26,945,217.00	4,748,483.00
210301	Гэрэл, цахилгаан	3,867,000.00	2,732,954.00	1,134,046.00
210302	Түлш, халаалт	26,426,700.00	23,512,263.00	2,914,437.00
210303	Цэвэр, бохир ус	1,400,000.00	700,000.00	700,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,456,900.00	8,681,410.00	775,490.00
210401	Бичиг хэрэг	2,228,500.00	2,211,700.00	16,800.00
210402	Тээвэр, шатахуун	1,976,700.00	1,976,700.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,809,100.00	1,138,040.00	671,060.00
210404	Ном, хэвлэл	0	0	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	201,200.00	120,000.00	81,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,241,400.00	3,234,970.00	6,430.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,600,000.00	4,588,442.00	11,558.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,200,000.00	2,190,442.00	9,558.00
210604	Урсгал засвар	2,400,000.00	2,398,000.00	2,000.00
2107	Томилолт, зочны зардал	808,400.00	777,000.00	31,400.00
210702	Дотоод албан томилолт	808,400.00	777,000.00	31,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,380,900.00	6,087,852.89	293,047.11
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,356,700.00	4,247,772.89	108,927.11
210803	Даатгалын үйлчилгээ	800,000.00	797,100.00	2,900.00

Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210804	Тээврийн хэрэгслийн татвар	59,000.00	55,900.00	3,100.00
210807	Газрын төлбөр	48,000.00	0	48,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,117,200.00	987,080.00	130,120.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	838,600.00	838,600.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	838,600.00	838,600.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,898,390,700.00	14,589,903,652.00	308,487,048.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,898,390,700.00	14,589,903,652.00	308,487,048.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	14,893,890,700.00	14,585,503,371.00	308,387,329.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,500,000.00	4,400,281.00	99,719.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	15,170,690,300.00	13,467,162,853.71	1,703,527,446.29
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,018,041,300.00	18,671,300.00	2,999,370,000.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	3,018,041,300.00	18,671,300.00	2,999,370,000.00
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	12,152,649,000.00	13,444,627,436.37	- 1,291,978,436.37
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	12,152,649,000.00	13,444,627,436.37	- 1,291,978,436.37
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0	3,864,117.34	-3,864,117.34
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	3,553,261.81	-3,553,261.81
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	310,855.53	-310,855.53
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	2,529,463,062.71	- 2,529,463,062.71
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	4,176,630,185.17	- 4,176,630,185.17

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
21	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,912,000.00	285,000.00
210	УРСГАЛ ЗАРДАЛ	1,912,000.00	285,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,912,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,912,000.00	
2109	Бараа, ажил үйлчилгээний зардал		285,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		285,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,912,000.00	285,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,912,000.00	285,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид олгосон санхүүжилт	1,912,000.00	285,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээ хийх, сангийн дансны авлагыг бууруулж ажиллах талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Батсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 08 дугаар албан бичгээр хуульд заасан хугацаанд ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тайлант онд аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь эерэг хандлага, цахим үйлчилгээний хөгжүүлэлтийн жил болгох зорилтыг дэвшүүлсэн байна.

Тус зорилтын хүрээнд НДЕГ-ын мэдээллийн технологийн төсвөөс 2021 оны 01 дүгээр улиралд нийгмийн даатгалын дэврийг цахим болгож, нийгмийн даатгал аппликейшн болон даатгуулагчийн вэбтэй холбосон байна.

2021 онд иргэд даатгуулагч, ажил олгогчдод чиглэсэн 17 удаагийн сургалт хийсэн бөгөөд сургалтад 983 иргэн хамруулж, 258 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авч үр дүнг нэгтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар, түүний дотор дотоод аудитор нь тайлант онд тус газрын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Нийгмийн даатгалын сан нь 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн зардлын 17,505,068.8 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 87,525.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 70,020.2 мянган төгрөгөөр тогтоосон

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,009,713.8 мянган төгрөгөөр буюу 19.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын оролцоо дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,529,463.1	4,176,630.2	1,647,167.1
Авлага	7,092,903.0	7,478,529.3	385,626.3
Урьдчилгаа			0.0
Бараа материал	12,018.7	8,122.0	-3,896.8
Үндсэн хөрөнгө	802,344.6	783,161.8	-19,182.9
Нийт хөрөнгө	10,436,729.5	12,446,443.2	2,009,713.8
Өр төлбөр	153,072.4	198,252.0	45,179.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	10,283,657.1	12,248,191.2	1,964,534.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	10,436,729.5	12,446,443.2	2,009,713.8

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 4,176,630.2 мянган төгрөг болж 1,647,167.1 мянган төгрөгөөр өссөн нь арилжааны банкнуудад тэтгэмжийн үлдэгдэлтэй гарсантай холбоотой байна.

Арилжааны банкинд 4,128,872.9 мянга, төрийн сангийн харилцах дансанд 47,757.3 мянган төгрөг тус тус байна.

Авлага дансны үлдэгдэл 7,487,529.3 мянган төгрөг болж 385,626.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд НДШ-ийн авлага, бусад авлага, улсын төсвөөс авах НДШ-ийн чөлөөлөлтийн авлага, санхүүгийн дэмжлэгийн авлага тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Авлагын үлдэгдэлд НДШ-ийн авлага 6,072,587.1 мянга, актын төлбөрийн авлага 12.8 мянга, бусад авлага 31,372.4 мянга, НДШ-ийн чөлөөлөлтийн авлага 1,269,157.1 мянга, санхүүжилтийн дэмжлэгийн авлага 105,400.0 мянган төгрөг тус тус байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 8,122.0 мянган төгрөг болж 3,896.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд өмнөх оны сэлбэг хэрэгсэл, хангамжийн материалыг зарцуулсан нь нөлөөлжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 12,018.7 мянган төгрөг байснаас тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 12,011.9 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан 704.5 мянга, нийт 12,716.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, 16,613.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 8,122.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 976,717.4 мянган төгрөг болж 18,735.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг бага үнээр дахин үнэлж данснаас хассантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 995,452.7 мянган төгрөг байснаас тайлант онд НДЕГ-аас 2,480.0 мянган төгрөгийн киоск төхөөрөмжийг үнэ төлбөргүй, НДЕГ-ын 2021.12.30-ны А/179 тоот тушаалаар ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг 12,768.0 мянган төгрөгөөр дахин үнэлж, нийт 15,248.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, НДЕГ-ын 2021.12.30-ны А/179 тоот тушаалаар ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг 32,021.5 данснаас хасаж, НДЕГ-ын 2021.12.30-ны А/180 тоот тушаалаар 1,961.8 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, нийт 33,983.3 мянган төгрөгөөр хасагдаж, 976,717.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Тайлант онд биет бус хөрөнгөнд өөрчлөлт ороогүй байна.

Өглөгийн үлдэгдэл 198,252.0 мянган төгрөг болж 45,179.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд санхүүжилт хүрэлцээгүйгээс сангаас олгох ХЧТАТ-үүдийг олгоогүй нь нөлөөлсөн байна.

Өглөгийн үлдэгдэл 198,252.0 мянган төгрөг нь тэтгэмжийн өглөг 162,485.0 мянга, бусад өглөг 8,409.3 мянга, урьдчилж орсон НДШ-ийн орлого 27,357.7 мянган төгрөг тус тус байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 12,248,191.2 мянган төгрөг болж 1,964,534.2 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оны тэтгэмжийн олголт 8,677.6 мянган төгрөгөөр хасагдаж, тайлант хугацааны үр дүн 1,955,856.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,367,426.6 мянган төгрөгөөр буюу 6.3 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс сангийн орлого 1,495,027.3 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлого 10,391.7 мянга, нийт 1,505,418.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, татаас санхүүжилтийн орлого 2,843,928.2 мянга, хүүгийн орлого 28,042.3 мянга, бусад орлого 874.9 мянга, нийт 2,872,845.4 мянган төгрөгөөр буурч материаллаг өөрчлөлт гарсан.

Тайланд онд дээд шатны төсвийн захирагчаас авах санхүүжилт буурсан, үнэ төлбөргүй орлого хүлээн авсан зэрэг нь нөлөөлжээ.

Нийт зардал өмнөх оноос 834,205.8 мянган төгрөгөөр буюу 4.7 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс урсгал засвар, Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмжийн зардал нь тус тус материаллаг өөрчлөлт гарсан байна.

Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Энэ нь тайлант онд барилгын засвар хийсэн, тэтгэмжийн зардлууд тус тус нэмэгдсэн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд сангийн өмнөх оны тэтгэмжийн олголт 8,677.6 мянган төгрөгөөр нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Нийгмийн даатгалын сангийн орлогыг 13,241,992.3 мянга, сангийн зарлагыг 15,927,298.2 мянга, үйл ажиллагааны урсгал зардлыг 326,062.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс сангийн орлогыг 3,712,737.2 мянган төгрөгөөр бууруулж 9,529,255.1 мянга, сангийн зарлагыг 1,179,362.2 мянган төгрөгөөр бууруулж 14,747,936.0 мянга, урсгал үйл ажиллагааны төсвийг 49,281.4 мянган төгрөгөөр бууруулж 276,780.6 мянган төгрөгөөр тус тус баталсан байна.

Сангийн орлогын төлөвлөгөөг анх 9,529,255.1 мянган төгрөгөөр батлагдсан боловч төсвийн тодотголоор тэтгэврийн сангийн орлогыг 451,322.3 мянган төгрөгөөр бууруулж, тэтгэмжийн сангийн орлогыг 2,387.4 мянга, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний сангийн орлолыг 3,069.7 мянга, ажилгүйдлийн даатгалын сангийн орлогыг 547.5 мянга, нийт 6,014.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 9,083,947.4 мянган төгрөгөөр тодотгож баталсан байна.

Сангийн зарлагын төлөвлөгөөг анх 14,747,936.0 мянган төгрөгөөр батлагдсан боловч төсвийн тодотголоор үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний сангийн зарлагыг 21,000.0 мянган төгрөгөөр бууруулж, тэтгэврийн сангийн зарлагыг 20,000.0 мянга, тэтгэмжийн сангийн зарлагын 147,940.7 мянга, нийт 167,940.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 14,894,876.7 мянган төгрөгөөр тодотгож баталсан байна.

Үйл ажиллагааны зардлын төсөв анх 276,780.6 мянган төгрөгийн төсөв батлагдсан боловч төсвийн тодотголоор бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардлыг 1,241.4 мянга, багаж, техник, хэрэгсэл зардлыг 700.0 мянга, урсгал засварын зардлыг 1,400.0 мянга, нийт 3,341.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, НДШ-ийн зардлыг 967.0 мянга, шуудан холбоо интернэтийн зардлыг 700.0 мянга, дотоод албан томилолтын зардлыг 200.0 мянга, аудит баталгаажуулах зэрэглэл тогтоох зардлыг 1,080.0 мянга, мэдээллийн технологийн үйлчилгээний зардлыг 1,000.0 мянга, өмгөөлөл зөвлөх үйлчилгээний зардлыг 200.0 мянга, сургалт семинар зохион байгуулах зардлыг 161.4 мянга, 4,308.4 мянган төгрөгөөр бууруулж, 275,813.6 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021.12.27-ны өдрийн 22 дугаар тогтоолоор нийгмийн даатгалын санд 9,083,947.4 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 13,466,852.0 төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 148.2 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Сангийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Тэтгэврийн сангийн орлого	7,677,353.4	11,102,904.1	3,425,550.7	44.6
Тэтгэмжийн сангийн орлого	644,626.3	1,029,609.3	384,983.0	59.7
ҮОМШӨДС-гийн орлого	625,397.3	1,104,959.0	479,561.7	76.7
Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого	136,570.4	229,379.6	92,809.2	68.0

Нийт дүн	9,083,947.4	13,466,852.0	4,382,904.6	48.2
-----------------	-------------	--------------	-------------	------

Нийгмийн даатгалын сангийн орлого нийт дүнгээр 4,382,904.6 мянган төгрөгөөр буюу 148.2%-иар давж биелсэн байна.

Сангийн орлогын нэр төрлөөр Тэтгэврийн сангийн орлого 3,425,550.7 мянган төгрөгөөр буюу 44.6%-иар, тэтгэмжийн сангийн орлого 384,983.0 мянган төгрөгөөр буюу 59.7%-иар, ҮОМШӨДС-гийн орлого 479,561.7 мянган төгрөгөөр буюу 76.7%-иар, ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 92,809.2 мянган төгрөгөөр буюу 68.0% тус тус давж биелсэн байна.

Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2021.12.27-ны өдрийн 22 дугаар тогтоолоор нийгмийн даатгалын санд 14,894,876.7 мянган төгрөгийн зардал зарцуулахаар батлагдсанаас гүйцэтгэлээр 14,586,359.3 мянган төгрөгийг зарцуулж, төсвийг 2.1 хувиар хэмнэсэн байна.

Хүснэгт 3. Сангийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Тэтгэврийн сангийн зарлага	12,700,868.6	12,575,294.6	125,574.0	1.0
Тэтгэмжийн сангийн зарлага	1,272,185.0	1,271,323.9	861.1	0.1
ҮОМШӨДС-гийн зарлага	404,825.0	324,855.0	79,970.0	19.8
Ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага	516,998.1	414,885.8	102,112.3	19.8
Нийт дүн	14,894,876.7	14,586,359.3	308,517.4	2.1

Нийгмийн даатгалын сангийн зардлыг нийт дүнгээр 308,517.4 төгрөгөөр буюу 2.1%-иар хэмнэсэн байна.

Сангийн зарлагын нэр төрлөөр Тэтгэврийн сангийн зардал 125,574.0 мянган төгрөгөөр буюу 1.0%-иар, тэтгэмжийн сангийн зарлага 861.1 мянган төгрөгөөр буюу 0.1%-иар, ҮОМШӨДС-гийн зарлага 79,970.0 мянган төгрөгөөр буюу 19.8%-иар, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 102,112.3 мянган төгрөгөөр буюу 19.8% тус тус хэмнэсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “71901-Нийгмийн” 1 хөтөлбөрийн хүрээнд 80801-үндсэн үйл ажиллагааны арга хэмжээг санхүүжүүлэхээр 266,956.9 мянга, 80205-мэдээлэл сурталчилгааны арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,000.0 мянга, 80224-зөвлөл хороо комиссын гишүүдийн арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,356.7 мянга, 80813-хуульд заасан үндэслэлээр албан хаагчид олгох арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,500.0 мянга, 80820-бусад тусламж дэмжлэгийн арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,000.0 мянга 275,813.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 275,813.6 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 275,813.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, 266,290.9 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 9,522.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 266,290.9 мянган төгрөг буюу 96.55 хувьтай байгаа нь бүрэн орон тоогоор ажиллаагүйгээс цалин, НДШ-ийн зардлыг 3,693.2 мянга, байр ашиглалтын тогтмол зардлыг 4,748.3 мянга, хангамжийн бараа материалын зардлыг 775.5 эд хогшил худалдан авах зардлыг 11.6 мянга, дотоод албан томилолтын зардлыг 31.4 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 162,9 мянга, бусад урсгал шилжүүлгийн зардлыг 99.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүүгийн үр дүнгийн тайланд сангийн орлого 16,267,074.9 мянга, улсын төсвөөс авах татаас санхүүжилтийн орлого 3,716,900.0 мянга, хүүгийн орлого 14,985.9 мянга, үйл

Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

ажиллагааны санхүүжилт 275,813.6 мянга, үнэ төлбөргүй үндсэн хөрөнгийн орлого 15,248.0 мянга, үнэ төлбөргүй бараа материалын орлого 704.6 мянга, НДШ-ийн алдангийн орлого 3,808.8 мянга, нэмэлтийн санхүүжилт 285.0 мянга, үнэт цаас, лавлагааны орлого 310.5 мянга нийт 20,295,131.3 мянган төгрөгийн орлого, санхүүжилтийг тайлагнасан байна.

Мөнгөн гүйлгээний тайланд сангийн орлого 15,887,585.8 мянга, улсын төсвөөс авах татаас санхүүжилтийн орлого 3,735,571.3 мянга, буцаагдсан санхүүжилт 25,958.3 мянга, хүүгийн орлого 14,985.9 мянга, үйл ажиллагааны санхүүжилт 275,813.6 мянга, нэмэлтийн санхүүжилт 285.0 мянга, үнэт цаас, лавлагааны орлого 310.5 мянга нийт 19,940,510.4 мянган төгрөгийн орлого, санхүүжилтийг тайлагнасан байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар сургалтын санхүүжилт 285.0 мянган төгрөгийг хүлээн авч, сургалтын хоолны зардалд зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитаар Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108, А/111 дүгээр тушаалаар батлагдсан ерөнхий чиглэлд тусгагдсан асуудлыг онцлон үзсэн боловч зөрчил илрээгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тухайн байгууллагад онцлох асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээллийн давхардал, ач холбогдол үр нөлөөг харгалзан Шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Говьсүмбэр аймгийн “Нийгмийн даатгалын хэлтэс” нь 2021 онд нийт 305,708.7 мянган төгрөгийн 35 мэдээллийг байршуулахаас 25,412.3 мянган төгрөгийн 14 мэдээллийг байршуулаагүй байна. Үүнд:

1. Хөрөнгө зарцуулах 1,900.0 мянган төгрөгийн 6 тушаал
2. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1 ажил үйлчилгээний 23,512.2 мянган төгрөгийн худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн

Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг тус тус мэдээлээгүйд зөрчлийг арилгах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгах 2 албан шаардлага, 4,453.9 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2		2		-	-	-
Зөвлөмж	3	4,453.9	3	4,453.9			
Нийт дүн	5	4,453.9	5	4,453.9	-	-	-

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагаанд анхаарал татахуйц асуудал байхгүй байна

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 34,986.9 мянган төгрөгийн 11 алдаа зөрчил илэрснээс, 2,233.9 мянган төгрөгийн 5 алдааг залруулж, 1,039.1 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 30,113.9 мянган төгрөгийн 2 албан шаардлага өгч, зөрчлийг давтан гаргахгүй байх 1,600.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын 2,233.9 мянган төгрөгийн 5 алдааг залруулав. Үүнд:

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлийг 227.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгасныг завсрын аудитаар залруулсан
- 2021 оны эхний хагас жилд бараа тайланд шатахууны орлого, зарлагыг 162.0 мянган төгрөгөөр дутуу тусгасныг завсрын аудитаар залруулсан
- 2021 оны эхний хагас жилд сэлбэгийн 1,153.4 мянган төгрөгийн тайлан гаргаагүй байсныг завсрын аудитаар залруулсан
- Мөнгөн гүйлгээний тайланд ташаарсан орлого 441.7 мянган төгрөгийг тусгасныг аудитын явцад залруулсан
- Нийгмийн даатгалын тайланд ЭХМК-ын 2 дугаар улирлын цалинг 249.3 мянган төгрөгийг дутуу тусгасныг аудитын явцад залруулсан

4.2. Төлбөрийн акт

4.2.1. 4 ажилтанд ээлжийн амралтын олговор, цалинг давхардуулан 807.1 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.5 дахь заалтуудыг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

4.2.2. Ажиллагсад урамшуулал, тэтгэмж олгохдоо нийт 232.0 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутган тооцоогүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.7, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 22 дугаар зүйлийн 22.1.1, Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/261 дугаар тушаалын хавсралтын 2.2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

4.3.1 Шилэн дансны цахим хуудсанд хөрөнгө зарцуулах 1,900.0 мянган төгрөгийн 6 захирамж, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил үйлчилгээний 23,512.2 мянган төгрөгийн худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг тус тус мэдээлээгүй, Нийгмийн даатгалын сан нь 31 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зэрэг нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.5 дахь заалтуудыг зөрчсөн ба санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

4.3.2 Татварын цахим бүртгэлийн системд худалдан авалтыг бүрэн шивэгдсэн эсэхэд хяналт тавьж ажиллаагүй, худалдан авалтын үнийн дүнг 2,897.0 мянган төгрөгөөр илүү, 1,804.6 мянган төгрөгөөр дутуу шивсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.4, Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалаар батлагдсан журмын 6 дугаар зүйлийн 6.5, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "ААНБ-ын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-д заасныг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Анхан шатны бүрдэл дутуу баримтаар 1,600.0 мянган төгрөгийн гүйлгээг бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.4, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "ААНБ-ын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-д заасныг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийхгүй байх, зөрчлийг давтан гаргахгүй байх

2. Балансын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Сангийн авлагыг өмнөх оноос нэмэгдүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8 зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлж, дансны авлагыг бууруулж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

Д/Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс	11	34,986.9	5	2,233.9	2	1,039.1	2	30,113.9	2	1,600.0